



БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Багшлахуйн арга зүйг үндэсний
хэмжээнд түгээн дэлгэрүүлэх
бүсчилсэн сургалт.
УБ. 2011.11.01-05



Хичээлийн судалгааны арга зүй

Т.Ганбаатар. МУБИС. МаСС
М.Ганбат. МУИС. ФЭС

Агуулга

1. Хичээлийн судалгаа
2. Хичээлийн судалгааны зорилго, ач холбогдол
3. Хичээлийн судалгааны жишээ

1. Хичээлийн судалгаа- Японд

Японы боловсролын түүх-хичээлийн судалгаа (Үндсэн модуль)

Хичээлийн судалгаагаар холбоотой хэрэглэж буй нэр томъёо:

Judookenkyu (Жюгёкенкю)-хичээлийн судалгаа

Kyozaiokenkyu-(Кёзайкенкю)-Хичээлийн хэрэглэгдэхүүн, хичээлийн бэлтгэл судалгаа

- Хичээлийн судалгаа- гэдэг нь багш нарын багшлах ур чадвар, арга зүйгээ системтэйгээр хөгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа юм.
(Makoto Yoshida)

- Японд 100-аад жилийн өмнөөс хичээлийн судалгаа хийж эхлэн,
- 1990-ээд оноос Америкийн бага сургуульд энэхүү арга барил шинээр нэвтэрсэн.
- Энд боловсронгуй болсон зарим шинэ арга нь буцаад Японд хэрэглэгдэх болсон юм. Жишээ: нэг ижил хичээлийг олон удаа давтаж хичээлийн судалгаа хийснээр тэр болгонд заах аргаа улам сайжруулах боломж бүрддэгийг илрүүлсэн.

Японы хичээлийн судалгааг дэлхийд таниулсан нь

- Анх дэлхий дахинд түгэн дэлгэрэх болсон шалтгаан бол Герман, Япон, Америкийн боловсролыг харьцуулсан судалгаа хийж байсан боловсрол судлаач Stigler.J. W-ийн гаргасан ном гэж үздэг.
- Стиглер энэ номыг гаргаснаар АНУ боловсролдоо нэлээд анхаарал тавьсан ба бага ангийн математикийн хичээл дээр хамгийн анх хичээлийн судалгааг туршиж үзсэн явдал юм.

Хичээлийн судалгаа-Дэлхийн ХЭМЖЭЭНД

- Дэлхийн холбоо 2006 онд Гонконгод байгуулагдсан.
- Одоо АНУ, Хятад, Тайланд, Малайз, Австрали, Иран, Швед, Англи, Монгол гэсэн орнуудад түгэн дэлгэрч байна.
- Хичээлийн судалгаа нь хөгжихийн хэрээр загвар болж буй Японы хичээлийн судалгааны талаар маш их мэдээлэл, ном хэвлэл, судалгаа гарч буй бөгөөд эдгээр нь эрэлт хэрэгцээтэй байсаар байна.
- Хайх түлхүүр үг: (**LESSON STUDY**)

Хичээлийн судалгааны үйл ажиллагаа нь багш нар хамтран хичээлийн төлөвлөлтөө хийхээс эхэлнэ. Багш нар тэдний ажлын туршлага, сурагчдаа ажигласан төлөв байдал, багшийн ном болон сурах бичиг дэх сайн туршлага, санаа зэрэгт тулгуурлан хичээлээ хэрхэн хамгийн сайн хичээл болгож болох талаар санаа бодлоо солилцоно. Энэхүү алхмын эцэст хичээл заах детальчилсан төлөвлөгөө бий болно.

Дахин заах,
сайжруулах

Хичээлийн
судалгаа
тасралтгүй
үйл ажил

Энэ алхамд нэг багш нь төлөвлөсөн хөтөлбөрийн дагуу хичээлээ зааж, бусад багш нар нь ажиглалт хийнэ. Ажиглалт хийх багш нар хичээлийн хөтөлбөртэй танилцсан байна.

Ажигласан багш нараас нэг багш тухайн хичээлийг өөр ангид дахин зааж, бусад нь ажиглалт хийнэ. Үүний үр дүнд хичээлийн арга зүй, төлөвлөлт улам илүү сайжирна.

Хэлэлц
явуу

ажиглалт хийсэн бүх хүмүүс оролцох ба хамтран боловсруулсан хичээлийн төлөвлөлт арга зүйн талаар, түүнийг хэрхэн сайжруулах талаар санаа бодлоо хэлэлцэж дүгнэнэ.




Photo 1: A study lesson class with observers

Figure 1: Flowchart of Pedagogical Training (Stigler & Hiebert, 1999)

2. Хичээлийн судалгааны зорилго, ач холбогдол:

- Идэвхи санаачлагатай багш нарын нээсэн шинэ арга барилыг нээлттэй хичээлээр бүгдэд таниулж, багш нарын санал дүгнэлтийн үндсэн дээр энэхүү арга барилаа улам боловсронгуй болгох
- Багш нар хүүхдийг илүү ойлгож, хүн бүрт үр өгөөж өгч чадахуйцаар хамтдаа хичээлээ хөгжүүлэх
- Хүнд арга барил үзүүлэх, хүний арга барилыг үзэж таних нь хоёр талдаа хөгжин дэвших боломж олгоно.
- Багш хичээлийн арга зүйгээ өөрчилснөөр өөрөө, улмаар хүүхдүүд ч бас өөрчлөгдөж байгааг мэдрэх
- Мөн яагаад арга зүйгээ шинэчлэх ёстой талаар ойлгох нь чухал

- **Хичээлийн судалгаанд үнэлгээ шаардлагагүй**
- Хичээлийн судалгаа нь нийт оролцогчид хэлэлцэж илүү сайн заах аргыг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
 - Тиймээс оролцогчид нь бүгд арга зүйн талаар өөртөө өгөөж хүртэнэ.
 - Мөн тэр арга зүйг шинэчлэхэд бас хувь нэмрээ оруулна.

Хичээлийн судалгааны түвшин

- Шинэ арга зүйг олж судлахад зориулсан
- Сургалтын зорилготой (мэргэжил дээшлүүлэх сургалт гэх мэт)
- Туршлагатай багш нар залуу багш нартаа сургах (туршлага судлах)
- Залуу багш нар туршлагатай багш нараасаа санал зөвлөмж авах
- Ижил түвшний багш нар бие, биеэсээ суралцах

Арга зүйг түгээн дэлгэрүүлэх тухайд удирдлагын
(*сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч,
сургалтын менежер*) үүрэг үндсэндээ 3 зүйл
байна.

- Багшийн туршлагаас хамааран, гүнзгийрсэн сургалттай, түвшин ахих төлөвлөгөөг багш бүрт гаргахыг чиглүүлэх
- Хичээлийн судалгааг зүгээр л нэг багшийн заах аргыг сайжруулах зүйл гэж ойлголгүй сургуулийн өмнөх зорилт, сургуулийн сурган хүмүүжүүлэх зорилтыг нарийвчлан гүйцэтгэх сэдвийг тогтооход чиглүүлэх
- Багш хичээлийн бэлтгэл судалгааг явуулан туршилт хичээл явуулах боломж, эрхийг чөлөөтэй байлгах

Арга зүйн
хөгжил:

- Сургууль төвтэй
- Судалгаа төвтэй

Хичээлийн
бэлтгэл
судалгаа:

- Судлах агуулга, судлагдахууны судалгаа
- Мэдлэг эзэмшилтийн судалгаа
- Арга зүйн судалгаа
- Үнэлгээний судалгаа
- Хэрэглэгдэхүүний судалгаа

Хичээлийн
судалгаа:

- Сэдэв, зорилгоо тодорхойлох
- Хамтран төлөвлөгөө боловсруулах
- Хичээл заах, ажиглах
- Хэлэлцэх, сайжруулах

“Хичээлийн бэлтгэл судалгаа”- гэдгийн дор юуг ойлгож байна вэ?

- **Ухагдахуун** (kyozai kenkyu, jyugyo kenkyu, koukai kenkyu, jyugyo kentoukai,....)
- 2006- **jyugyo kenkyu**, 2007- **kyozai kenkyu**,
- **Асуудал: Хичээлийн үр дүнгээ улам сайжруулахын тулд бид яах ёстой вэ?**
 - Урьдчилан төлөвлөлтийг бодит судалгаанд түшиглэж хийх
 - Хичээлийн үйл явцдаа судалгаа хийж, хичээлийн төлөвлөлтөө улам сайжруулах
- **Эргэлзээ:**
 - Бид ч хичээлийг төлөвлөдөг. Конспект, киррикулим хийдэг. Тийм биш гэж үү?
 - Юугаараа ялгаатай юм бэ?



Хичээлийн судалгааны систем (Япон)

1	Сургууль төвтэй хичээлийн судалгаа	Сургуулийн удирдлага, багш нар
2	Аймаг, мужийн судалгааны бүлэг	Сургуулийн багш нар (хамтран ажиллах)
3	Аймаг, мужийн судалгааны бүлэг	Боловсролын газар
4	Улсын түвшинд	Их Сургуулийн харьяа сургууль, багш нар
5	Улсын түвшинд	Байгууллага, холбоо,

Сургууль төвтэй хичээлийн судалгаа

- Сэдвээ сонгох
- Сэдвээ судлах, жилийн төлөвлөгөөндөө тусгах, бэлтгэх
- Хичээлийн судалгаа явуулах
- Хэлэлцэх, сайжруулах
- Жилийн төлөвлөгөө, үйл ажиллагааг дахин хэлэлцэх

3. Хичээлийн судалгааны жишээ




Figure 3: National Training Conference for Teachers at the Elementary School Attached to the University of Tsukuba, held since the Meiji period.

Сургуулийн түвшний нэгэн жишээ

Хичээлийн судалгаа хийх чиглэл, сэдвээ сонгох:

Тухайн хичээлийн судалгааны чиглэл, сэдвийг сонгохын тулд багш нарыг бүгдийг нь анхны хэлэлцүүлэгт татан оролцуулах хэрэгтэй. Энэ нь ихэвчлэн хичээлийн судалгааны үйл ажиллагааны эхлэл болдог. Судалгааны чиглэл нь ихэвчлэн сурагчдын суралцахуйн өнөөгийн төлөв байдал болон ялгаа, багшлахуйн дэмжлэг хир байж болох, эдгээрийг хэрхэн шийдвэрлэх талруу чиглэдэг.

Ийм хэлэлцүүлгийн үр дүнд бий болсон судалгааны чиглэлээ багш нар хичээлийн судалгааг хэрэгжүүлэх, удирдан чиглүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааны гол сэдэв болгож авдаг. Хичээлийн судалгааны сэдэв нь хичээлийн судалгааны амжилтыг тодорхойлоход чухал болно.

- Сургуулийн бүх багш нарын уулзалт:
 - Сурагчдын суралцахуйн өнөөгийн төлөв байдал,
 - Суралцахуйд гарч буй доголдол, бэрхшээл, өөрсдийн дэмжлэг, туршлага
- Жишээлбэл: Хирошима хотын TSUTA бага сургуулийн багш нар:

“Манай сургуулийн сурагчид, хөгжилтэй, баяр баясгалантай, дуулгавартай, суралцах маш их урам зоригтой. Гэвч тэд нэг асуудлыг гүн гүнзгий анхаарах, бусад сурагчийнхаа тайлбарт анхаарал хандуулах, сонсох чадвар муу, бусад сурагчийн шүүмжийг хүндэтгэн хүлээн зөвшөөрдөггүй. Ялангуяа 5 ба 6 дугаар ангийн сурагчид бусад сурагчдынхаа өмнө алдаа хийх, алдаа гаргахаас улам ихээр айдаг болж байна. Үүнээс шалтгаалаад тэд суралцах үйл ажиллагаанд идэвхитэй оролцох хүсэл сонирхолгүй болж байна.” гэж хэлэлцээд хичээлийн судалгааны багийнхан судалгааны чиглэлээ **“Сурагчдын өөрийнхөөрөө бодож, сэтгэх чадвар, нээлт хийх, бие биенээсээ суралцах чадварыг дэмжих”** гэж тодорхойлж авч үзсэн байна.

**АНХААРАН
СОНССОНД
БАЯРЛАЛАА.
Амжилт хүсье.**